



МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2022 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 39

Улаанбаатар хот

Зөвшөөрөл олгох тухай

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4, 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 66.1.6 дахь заалт, Соёлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэг, "Аймгийн Засаг даргын тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай" Засгийн газрын 2021 оны 377 дугаар тогтоол, "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам батлах тухай" Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 3 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Төрийн албаны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Соёл, урлагийн газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг хавсралт ёсоор шинэчлэн батлахыг Монгол Улсын Соёлын сайд /Ч.Номин/-д зөвшөөрсүгэй.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2021 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 232 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Хянаж зөвшөөрөл олгосон албан тушаалын тодорхойлолтыг албажуулж, баталж мөрдүүлэх, нэгдсэн санд бүртгэх үйл ажиллагааг мэргэшил, арга зүйн зөвлөгөөгөөр хангаж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /Ж.Эрдэнэбат/-нд даалгасугай.

ДАРГА



Б.БААТАРЗОРИГ



МОНГОЛ УЛСЫН
СОЁЛЫН САЙДЫН ТУШААЛ

2022 оны 08 сарын 15 өдөр

Дугаар А/16

Улаанбаатар хот

Аймаг, нийслэлийн Соёл, урлагийн газрын
даргын албан тушаалын тодорхойлолт
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Соёлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 2, Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4, Засгийн газрын 2021 оны “Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны бүтэц, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны орон тооны хязгаарыг батлах тухай” 360 дугаар тогтоолын 5.17, “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай” 377 дугаар тогтоолын 4.13, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 3 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын 5.1, Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн “Зөвшөөрөл олгох тухай” 39, 40 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Соёл, урлагийн газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг нэгдүгээр, Архангай аймгийн Соёл, урлагийн газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг хоёрдугаар, Баян-Өлгий аймгийн Соёл, урлагийн газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг гуравдугаар, Баянхонгор аймгийн Соёл, урлагийн газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг дөрөвдүгээр, Булган аймгийн Соёл, урлагийн газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг тавдугаар, Говь-Алтай аймгийн Соёл, урлагийн газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг зургаадугаар, Говьсүмбэр аймгийн Соёл, урлагийн газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг долоодугаар, Дархан-Уул аймгийн Соёл, урлагийн газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг наймдугаар, Дорноговь аймгийн Соёл, урлагийн газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг есдүгээр, Дорнод аймгийн Соёл, урлагийн газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг аравдугаар, Дундговь аймгийн Соёл, урлагийн газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг арван нэгдүгээр, Завхан аймгийн Соёл, урлагийн газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг арван хоёрдугаар, Орхон аймгийн Соёл, урлагийн газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг арван гуравдугаар, Өвөрхангай аймгийн Соёл, урлагийн газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг арван дөрөвдүгээр, Өмнөговь аймгийн Соёл, урлагийн газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг арван тавдугаар, Сүхбаатар аймгийн Соёл, урлагийн газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг арван зургаадугаар, Сэлэнгэ аймгийн Соёл, урлагийн газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг арван долоодугаар, Төв аймгийн Соёл, урлагийн газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг арван наймдугаар, Увс аймгийн Соёл, урлагийн газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг арван есдүгээр, Ховд аймгийн Соёл, урлагийн

14190010082

газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг хорьдугаар, Хөвсгөл аймгийн Соёл, урлагийн газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг хорин нэгдүгээр, Хэнтий аймгийн Соёл, урлагийн газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг хорин хоёрдугаар хавсралт ёсоор тус тус шинэчлэн баталсугай.

2. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2021 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн “Зөвшөөрөл олгох тухай” 232 дугаар тогтоолыг үндэслэн баталсан аймгийн Соёлын хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг хүчингүй болгохыг аймгийн Засаг дарга нарт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн “Зөвшөөрөл олгох тухай” 304 дүгээр тогтоолын 10 дугаар хавсралтаар баталсан Нийслэлийн Соёл, урлагийн газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг хүчингүй болгохыг нийслэлийн Засаг дарга нарт зөвлөсүгэй.



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Соёлын тухай хууль

Дагаж мөрдөх огноо:

2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Дархан-Уул аймгийн Соёл, урлагийн газар

Нэгжийн нэр:

Албан тушаалын нэр:

Соёл, урлагийн газрын дарга

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Ахлах түшмэл, ТЗ-10

Ажлын цаг:

Ажлын өдрийн 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Соёлын талаарх хууль тогтоомж, бодлого, шийдвэрийг нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх, аймгийн соёл, урлагийн хөгжлийн бодлогыг уялдуулан соёлын үнэт зүйлийг хамгаалах, соёл, урлагийн үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээд, иргэн болон холбогдох байгууллага, албан тушаалтныг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, дэмжлэг үзүүлэх чиглэлээр байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг Соёлын сайдын өмнө хариуцна.

Төрийн албаны зөвлөлийн
2022 оны 01 дүгээр сарын 31-ний
өдрийн 39 дүгээр тогтоолын хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо: Соёлын тухай хууль

Дагаж мөрдөх огноо: 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

... Аймгийн Соёл, урлагийн газар

Нэгжийн нэр:

Албан тушаалын нэр:

Соёл, урлагийн газрын дарга

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Ахлах түшмэл, ТЗ-10

Ажлын цаг:

Ажлын өдрийн 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Соёлын талаарх хууль тогтоомж, бодлого, шийдвэрийг нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх, аймгийн соёл, урлагийн хөгжлийн бодлогыг уялдуулан соёлын үнэт зүйлийг хамгаалах, соёл, урлагийн үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээд, иргэн болон холбогдох байгууллага, албан тушаалтныг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, дэмжлэг үзүүлэх чиглэлээр байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг Соёлын сайдын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1. Соёлын бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах, аймгийнхаа соёл урлагийн хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулах, хяналт тавих, тайлагнах;

2. Харьяалах нутаг дэвсгэрийнхээ соёлын үнэт зүйлийг хамгаалах, соёлын үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх, хүн амд соёлын боловсрол олгох, аймгийнхаа соёл, урлагийн хөгжлийн стратегийг төлөвлөх, батлуулах, хэрэгжүүлэх, холбогдох иргэн, албан тушаалтан, хуулийн этгээдэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

3. Байгууллагын үйл ажиллагааг төлөвлөх, өдөр тутмын удирдлагаар хангах, хяналт тавих, хүний нөөцийн болон төсвийн удирдлагыг хэрэгжүүлж, батлагдсан төсвийг үр ашигтай захиран зарцуулах, тайлагнах;

4.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх;

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Соёлын бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;	Хууль тогтоомжийг хэрэгжүүлсэн байх,	Г, Х
	2.Төрөөс баримталж буй соёлын бодлого төлөвлөлтийг аймгийн хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулан нутаг дэвсгэрийнхээ соёлын онцлог, соёлын өв, угсаатны бүлэгт тулгуурласан соёл, урлагийг хөгжүүлэх стратегийг боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх;	Бодлого, төлөвлөлт, стратегийн уялдааг хангаж, хэрэгжүүлсэн байх,	Г, Х, Ш
	3.Соёлын тухай болон шинээр батлагдсан хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгийг сурталчлах;	Хууль тогтоомжийг сурталчилж таниулсан байх,	Г, Х
	4.Соёлын салбарын хөгжлийн урт, дунд хугацааны бодлогын баримт бичигт санал гаргах, тулгамдаж буй асуудлаа танилцуулах, шийдвэрлүүлэх;	Бодлогын баримт бичиг, холбогдох асуудлаар санал гаргасан байх,	Г
	5.Нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжих хөтөлбөр арга хэмжээ, хөрөнгө оруулалт, байгууллагын болон холбогдох төсөвт	Хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж,	Г, Х, Ш



	байгууллагуудын үйл ажиллагааны төсвийг хуваарилах, хэрэгжилтийг хангуулах, тайлагнах;	тайлагнасан байх,	
	6.Салбарын хүрээнд батлагдан гарсан дүрэм, журам, аргачлал, стандартыг нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахад удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах;	Арга зүй, удирдлагаар хангаж, тайлагнасан байх,	Г, Х
	7.Салбарын сайд болон аймгийн Засаг дарга нарын хооронд байгуулах гэрээ, холбогдох бусад баримт бичигт санал өгөх, гэрээний хэрэгжилтийг хангах, хуваарилах, шинжилгээ хийх;	Хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлж, тайлагнасан байх,	Т, Г, Х
	8. Соёлын талаар аймгийн Засаг дарга болон сумын Засаг даргын нарын хооронд байгуулах гэрээ, холбогдох бусад баримт бичигт санал өгөх, шинжилгээ хийх;	Засаг захиргааны нэгж бүрд соёлын үйлчилгээг хүргэхэд дэмжлэг үзүүлсэн байх	Т, Г, Х
2 дугаар зорилтын хүрээнд	1.Байгаль орчин, уламжлалт ахуйтайгаа харилцан шүтэлцсэн нүүдлийн соёл иргэншлийн онцлогийг хадгалсан, угсаатны бүлэг, соёлын онцлогтоо тулгуурласан соёлын үйл ажиллагааг дэмжин хөгжүүлэх;	Соёл, урлагийн үйл ажиллагаанд холбогдох дэмжлэг үзүүлсэн байх,	Т, Г, Х, Ш
	2.Гэр бүлийн соёл, уламжлалыг бүх нийтэд сурталчлан таниулах, угийн бичиг хөтлөх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулах;	Угийн бичиг хөтлөх ажлыг эрчимжүүлсэн байх,	Г, Х, Ш
	3.Хүүхэд, залуучуудын авьяас, ур чадвар, бүтээлч үйл ажиллагааг хөгжүүлэх, бүх нийтэд соёлын боловсрол олгох ажлыг зохион байгуулж, удирдлагаар хангах;	Үйл ажиллагаа зохион байгуулсан байх,	Г, Х, Ш
	4.Аймаг, сумын музей, орон нутгийн байгаль, түүх, соёлын үнэт зүйлийг бүртгэх, цуглуулах, хадгалж хамгаалах, судлах, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ажлыг удирдлагаар хангах;	Соёлын өвийг хамгаалах, дэлгэрүүлэх ажлыг удирдлагаар хангасан байх,	Г, Х, Ш
	5.Үндэсний, сонгодог, орчин үеийн урлагийг тэгш хөгжүүлэх, бүтээл туурвих, аймгийн баяр наадам, томоохон урлагийн арга хэмжээ зохион байгуулах, алдаршуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх;	Үйл ажиллагааг зохион байгуулж, үр дүнд хүрсэн байх,	Г, Х, Ш
	6.Оюуны өмч болон зохиогчийн эрх, түүнд хамаарах бусад эрхийг хамгаалах, арга зүйн удирдлагаар хангах;	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангасан байх	Г, Х
	7.Соёлын бүтээлч үйлдвэрлэл,	Бүтээлч	Г, Х, Ш



	соёлын аялал жуулчлалыг дэмжин хөгжүүлэх, судалгаа, шинжилгээ хийх, мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг зохион байгуулах;	үйлдвэрлэлийг дэмжиж, үр дүнд хүрсэн байх,	
	8.Цахим шилжилтийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих;	Соёл, урлагийн үйл ажиллагааг цахимжуулсан байх,	Г, Х, Ш
	9.Аймгийнхаа соёл, урлагийн төсөв, санхүүжилтийн нөхцөл байдалд эдийн засаг, үр ашгийн шинжилгээ хийх, холбогдох байгууллагуудад мэргэжил дэмжлэг үзүүлэх, удирдлагаар хангах;	Үр ашгийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлсэн байх,	Г, Х, Ш
	10.Аймгийн соёл, урлагийн байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд санал өгөх, хянах, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дүгнэлт, зөвлөмж өгөх;	Арга зүйн удирдлага, дэмжлэг үзүүлж, дүгнэсэн байх,	Г, Х, Ш
	11.Аймгийн соёл, урлагийн байгууллагуудыг удирдлагаар хангах, хяналт-шинжилгээ хийж дүгнэлт, зөвлөмж өгөх;	Арга зүйн удирдлага, дэмжлэг үзүүлсэн байх,	Г, Х, Ш
	12.Хүний нөөцийг бэхжүүлэх, давтан сургах, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх;	Үйл ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлсэн байх,	Г, Х, Ш
3 дугаар зорилтын хүрээнд	1.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, дээд шатны удирдах албан тушаалтнаар хянуулан баталж, хэрэгжүүлэх;	Журам, дүрэмд заасны дагуу хэрэгжүүлсэн байх,	Г, Х, Ш
	2.Байгууллагын дотоод нэгжийн даргыг шууд удирдлагаар хангах, гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлах, дүгнэх;	Журам, дүрэмд заасны дагуу хэрэгжүүлсэн байх,	Г, Х, Ш
	3.Байгууллагын албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг дүгнэх, үр дүнг харгалзан урамшуулах;	Журам, дүрэмд заасны дагуу хэрэгжүүлсэн байх,	Г, Х, Ш
	4.Байгууллагын үйл ажиллагааг өдөр тутмын удирдлагаар хангаж, албан хаагчдыг ажил үүргээ гүйцэтгэхэд нь дэмжлэг үзүүлэх, байгууллагыг төлөөлж бусад байгууллагуудтай харилцах, хамтран ажиллах, ажлын уялдааг хангах;	Хууль тогтоомж, эрх зүйн актад заасан эрх, үүргийг хэрэгжүүлсэн байх,	Г, Х, Ш
	5.Захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангах, байгууллагын соёлыг төлөвшүүлэх;	Хууль тогтоомж, эрх зүйн актад заасны дагуу хэрэгжүүлсэн байх,	Г, Х, Ш
	6.Байгууллагын албан хаагчдыг хөгжүүлэх, ур чадварыг дээшлүүлэх, шагнах урамшуулах, хариуцлага тооцох талаар гарсан саналыг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх,	Хууль тогтоомж, эрх зүйн актад заасны дагуу хэрэгжүүлсэн	Г, Х, Ш



	холбогдох байгууллагад уламжлах;	байх,	
	7.Батлагдсан төсөв, сайдын баталсан зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарт багтаан орон тоо, цалингийн санг тогтоох;	Хууль тогтоомж, эрх зүйн актад заасны дагуу хэрэгжүүлсэн байх,	Г, Х, Ш
	8.Аймгийнхаа соёлын байгууллагуудын төсвийн төлөвлөлтийг нэгтгэн хүргүүлэх ажлыг удирдлагаар хангах;	Хууль тогтоомж, эрх зүйн актад заасны дагуу хэрэгжүүлсэн байх,	Х, Ш
	9.Орон нутаг, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй соёлын салбарын эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтийг хуулиар баталсан зориулалт, хүчин чадал, байршлын дауу хэрэгжиж байгаа эсэхэд хяналт тавих, санал гаргах;	Хууль тогтоомж, эрх зүйн актад заасны дагуу хэрэгжүүлсэн байх,	Х, Ш
	10.Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, тайланд хяналт тавих, төсвийн болон худалдан авах үйл ажиллагааны ил тод байдлыг хангах;	Хууль тогтоомж, эрх зүйн актад заасны дагуу хэрэгжүүлсэн байх,	Г, Х, Ш
4 дүгээр зорилтын хүрээнд	1. Хууль тогтоомж, бодлого, шийдвэр болон үйл ажиллагаатай холбоотой тайлан, мэдээг цагалбарт хугацаанд нь чанартай гаргах, тайлагнах;	Тайлан, мэдээг хугацаанд нь гаргасан байх,	Г, Х, Ш
	2. Аймгийн хэмжээний тайлан мэдээг нэгтгэж, цагалбарт хугацаанд нь холбогдох байгууллагуудад хүргүүлэх;	Хугацаанд нь хүргүүлсэн байх,	Г, Х, Ш
	3.Харьяа дээд байгууллагаас шаардсан ажлын чиг үүрэгтэй холбоотой мэдээлэл судалгааг тогтоосон хугацаанд нь шуурхай, чанартай, гаргаж өгөх;	Үнэн бодитой, шуурхай гаргасан байх,	Г, Х, Ш
	4.Харьяалах нутаг дэвсгэрийн соёл, урлагийн байгууллагын статистик мэдээллийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр цуглуулах, нэгтгэн дүгнэх, тайлагнах, мэдээллийн сан бүрдүүлэх;	Үнэн бодитой тайлагнасан байх,	Г, Х, Ш
	5.Албан хэрэг хөтлөлтийн стандартыг хэрэгжүүлж эрхлэх асуудлын чиг үүрэгт хамаарах мэдээ, мэдээлэл, тайлан, холбогдох материалыг “Хөтлөх хэргийн жагсаалт”-ын дагуу архивын нэгж болгон хадгалах ажлыг удирдлагаар хангах;	Архив албан хэрэг хөтлөлтийн стандартад нийцүүлсэн байх,	Г, Х, Ш
	6.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирсэн санал,	Үнэн бодитой шийдвэрлэсэн	Г, Х, Ш



	өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авч зохих журмын дагуу шуурхай шийдвэрлэх;	байх,	
	7. Байгууллагын зорилго, зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв, санхүү болон бусад чиглэлээр санал гаргах, төсвийн төслийг боловсруулах, батлуулах;	Хууль тогтоомж, эрх зүйн актад заасны дагуу хэрэгжүүлсэн байх,	Г, Х, Ш
	8. Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, эзэмшилд хяналт тавьж, баланст байгаа өмч хөрөнгийг зохих журмын дагуу эзэмшиж, ашиглах;	Хууль тогтоомж, эрх зүйн актад заасны дагуу хэрэгжүүлсэн байх,	Г, Х, Ш

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	- Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй	
Мэргэжил	<ul style="list-style-type: none"> - соёл судлал /031401/; - урлаг /021/; - номын сан судлал /032201/; - төрийн удирдлага, нийтийн удирдлага /041303/; - уран зохиол, хэл шинжлэл /0232/; - түүх, археологи /0222/; - антропологи /031403/; - эрх зүй /042101/; - багш-урлагийн боловсрол /011404/; - багш-монгол хэл, уран зохиолын боловсрол /011407/; - аялал жуулчлалын менежмент /041304/; - эдийн засаг /031101/; - менежмент, соёл, урлагийн. 	
Мэргэшил	- Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх;	
Туршлага	- Төрийн албанд 8-аас доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх.	
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> - нэгжийн үйл ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэлийг дүгнэх; - албан хаагчдын ажил үүргийг оновчтой хуваарилах; - албан хаагчдын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, зохих заавар чиглэл өгөх; - гарч болох эрсдэлийг урьдчилан тооцож, арилгах арга замыг тодорхойлох; - албан хаагчдын саналын зөрүү, үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - бусад.
	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> - албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээллийг цуглуулж харьцуулалт хийх, нэгтгэж дүгнэх; - судалгааны арга зүйн мэдлэгтэй, ашиглах чадвартай байх; - судалгааны дүн, мэдээлэлд тулгуурлан бодлогын үндэслэлтэй санал, дүгнэлт, зөвлөмж боловсруулах;



		<ul style="list-style-type: none"> - шийдвэрийн шууд ба шууд бус үр дагаврыг үнэлэх; - бусад.
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> - үндэсний язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж, төрд үнэнчээр зүтгэх; - хуульд нийцсэн, оновчтой шийдвэр гаргах; - асуудлыг хууль журам, ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - гаргасан шийдвэрийнхээ үр дагаврыг хариуцах; - аливаа асуудлыг шийдвэрлэхдээ хамт олны саналыг харгалзан үздэг байх; - бусад.
	Манлайлах	<ul style="list-style-type: none"> - ёс зүйгээр хамт олноо үлгэрлэн манлайлах; - шинэтгэлийн үзэл санааг хамт олондоо итгүүлэн ойлгуулах, хэрэгжүүлэх; - итгэлцлийг бий болгох, албан хаагчдад адил тэгш хандах; - шинэ санаа, зөв хандлагыг дэмжих; - ажил хэрэгч, бүтээлч, санаачилгатай байх; - хувийн зохион байгуулалт, ажлын цаг ашиглалт сайтай байх; - бусад.
	Бусад	<ul style="list-style-type: none"> - соёл, урлагийн чиглэлээр ажилласан бол давуу тал болно; - англи хэл эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх; - компьютерын хэрэглээний программ, мэдээллийн технологи ашиглах; - багаар ажиллах, багийн амжилтыг дэмжиж бусдад таниулах; - жендерийн эрх тэгш байдлыг хангах; - кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх чадвартай байх.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Соёлын сайд

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Нэгжийн дарга
Ахлах мэргэжилтэн
Мэргэжилтэн
Төрийн үйлчилгээний албан хаагчид
Нийт:

Бусад харилцах субъект

- соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
- нутгийн өөрөө удирдах байгууллага
- төрийн болон нутгийн захиргааны байгууллага;
- аймгийн соёл, урлагийн байгууллага
- төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрийн ажилтан,
- Иргэн

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:



<u>Албан тушаал:</u> Соёлын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Оюунбилэг 2022 оны .. дугаар сарын ... -ны өдөр	<u>Байгууллагын нэр:</u> ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ Шийдвэрийн огноо: 22 0131 Дугаар: 039
Албан тушаалын тодорхойлолт баталсан:	
<u>Байгууллагын нэр:</u> СОЁЛЫН ЯАМ <u>Шийдвэрийн огноо:</u> <u>Дугаар:</u> (тамга/тэмдэг) Соёлын сайд Ч.Номин 2022 оны дугаар сарын ... -ны өдөр	

